



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 7 сарын 07 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

“СПОРТ ЦОГЦОЛБОР” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 84 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. “Спорт цогцолбор” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. “Спорт цогцолбор” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ч.Жигжидсүрэнг 2003 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Гурав. Татан буугдаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарлах, байгууллага, хувь хүмүүсийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар барагдуулж, байгууллагын хаалтын багийнсыг 2003 оны 8 дугаар сарын 01-ний дотор гаргаж, холбогдох байгууллагад тушаахыг татан буулгах ажлыг зохион байгуулах комисс /М.Цэрэндорж/, “Спорт цогцолбор” /Ч.Жигжидсүрэн/-т даалгасугай.


Дөрөв. Байгууллагын бичиг баримтыг архивлан Нийслэлийн архивын албанд шилжүүлэх, тус газрын ажиллагсад болон өндөр настны асуудлыг Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу шийдвэрлэхийг татан буулгах ажлыг зохион байгуулах комисс /М.Цэрэндорж/, “Спорт цогцолбор” /Ч.Жигжидсүрэн/-т үүрэг болгосугай.

Тав. Дээрх захирамжийн биелэлтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2003 оны
2003.08.08 захирамжийн хавсралт

”Спорт цогцолбор” нийслэлийн өмчит
үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг
зохион байгуулах комисс

Комиссын дарга	М.Цэрэндож	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын орлогч дарга
Гишүүдэд	Б.Бүрэнцэцэг	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын мэргэжилтэн
	Н.Болормаа	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын мэргэжилтэн
	Г.Гансүрэн	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын мэргэжилтэн